



**“УУЛ УУРХАЙ БА ЭДИЙН ЗАСАГ:  
ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИЙДЭЛ”**



# **Нүүрстөрөгчийн хязгаарлалтад Монгол Улс дасан зохицох нь**

**Б.Түвшинтөгс (МУИС, ЭЗСЭШХ),**

**Д. Өнөржаргал (ЭЗСЭШХ)**

01/18/2022

# Агуулга



1. Олон улсын нүүрсхүчлийн хийг хязгаарлах бодлого
2. Монголын нүүрсний салбарын өнөөгийн байдал, баримталж буй бодлогууд
3. Арга зүй болон шинжилгээний хувилбарууд
4. Шинжилгээний үр дүн
5. Дүгнэлт

# *Нүүртөрөгчийг хязгаарлах бодлого*

# Олон улсын CO<sub>2</sub> –ийг хязгаарлах бодлого



- Парисын хэлэлцээр (2016) – Дэлхийн дулаарлын өсөлтийг 2°C-с доош байлгах зорилт тавьсан
  - 196 улс орон гарын үсэг зурсны дотор Монгол Улс мөн нэгдсэн.
- Хамгийн их хүлэмжийн хий ялгаруулагчид- БНХАУ, АНУ, Европын холбоо, Энэтхэг болон ОХУ
  - Их-20 –ийн орнууд нийт хүлэмжийн хийн 75%-ийг ялгаруулдаг
- Парисын гэрээний хэрэгжилт сул байна
  - Дэлхийн нийт хүлэмжийн хийн ялгаруулалт зорилтот түвшнээсээ өндөр байгаа
  - 2015-2019 онуудад CO<sub>2</sub> –ийн түвшин 2010-2015 оны түвшнээс 20% өндөр байсан.
- Гол ялгаруулагчид болох АНУ, БНХАУ, ОХУ зэрэг улсууд уг гэрээг дагаснаар хүлэмжийн хийг мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулах боломжтой

# Улс орнуудын бодлогууд



- Хамгийн их хүлэмжийн хий ялгаруулагчид (БНХАУ, ОХУ), нүүрс экспортлогч томоохон орнууд (Индонез, Австрали), нүүрсэнд суурилсан эрчим хүчний томоохон хэрэглэгч (Өмнөд Солонгос)

Улсууд	Одоогийн нөхцөл байдал	Зорилго ба стратегиуд
БНХАУ	<ul style="list-style-type: none"> <li>• Дэлхийн нийт CO<sub>2</sub> –ийн 29%</li> <li>• CO<sub>2</sub> –ийн ялгаруулалтаараа 2-т</li> <li>• CO<sub>2</sub> –ийн ялгаруулалт нь эдийн засгийн өсөлттэй хамааралтай</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Нэгж ДНБ-д ногдох CO<sub>2</sub> ялгаруулалтыг 2005 оны түвшнээс 65%-аар бууруулах</li> <li>• Нийт эрчим хүчний хэрэглээнд эзлэх сэргээгдэх эрчим хүчний хэмжээг 25%-д хүргэх</li> <li>• Нар, салхины эрчим хүчний суурилагдсан хүчин чадлыг 1.2 тэрбум кВт-д хүргэнэ.</li> <li>• 2060 он гэхэд нүүрс төрөгчийн “0” түвшинд хүрнэ</li> </ul>
ОХУ	<ul style="list-style-type: none"> <li>• 2019 онд 1,585 сая тонн CO<sub>2</sub> ялгаруулсан</li> <li>• CO<sub>2</sub> –ийн ялгаруулалтаараа 4-т</li> <li>• Дэлхийн хамгийн том эрчим хүчний нөөц эзэмшигчдийн нэг</li> <li>• Газрын тос, байгалийн хийн экспортоос ихээхэн хамааралтай</li> <li>• Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр баялаг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хүлэмжийн хийн ялгаруулалтыг 2030 он гэхэд 1990 оны түвшнээс 25-30%-аар бага түвшинд хүргэх</li> <li>• Барилгын эрчим хүчний хэмнэлтийн стандартыг сайжруулах, эрчим хүчний хэмнэлтийг урамшуулах зорилгоор тарифыг өөрчлөх, дулаан хангамжийг арилжааны системтэй болгох</li> <li>• 2030 он гэхэд сэргээгдэх эрчим хүчний нийт эрчим хүчний хэрэглээнд эзлэх хувийг 4.6%-д хүргэж нэмэгдүүлэх (одоо 3.6%)</li> <li>• 2060 оноос өмнө нүүрс төрөгчийн “0” түвшинд хүрнэ (албан ёсоор батлагдаагүй)</li> </ul>

# Улс орнуудын бодлогууд

Улсууд	Одоогийн нөхцөл байдал	Зорилго ба стратегиуд
Индонез	<ul style="list-style-type: none"> <li>• 2018 онд 542 сая тонн хүлэмжийн хий ялгаруулсан</li> <li>• Хээрийн болон ойн түймрээс шалтгаалан хүлэмжийн хийн ялгаруулалт нь нэмэгддэг</li> <li>• Нүүрсний 5 дахь том экспортлогч, нийт эрчим хүчнийхээ 60%-ийг нүүрснээс гаргадаг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• 2050 он гэхэд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн нийт эрчим хүчний нийлүүлэлтэд эзлэх хувийг 31%-д хүргэх, газрын тос болон нүүрсний эх үүсвэрийн хэмжээг 20% болон 30% -аас тус тус доошлуулах</li> <li>• Газар ашиглалт, ойн аж ахуйгаас ялгарах хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулахын тулд ойн хомсдол, доройтлыг үүсгэж буй хууль бус үйл ажиллагаатай тэмцэж байгаа</li> <li>• Хүлэмжийн хийн ялгаруулалтыг 2030 он гэхэд 29%-аар бууруулна</li> </ul>
Австрали	<ul style="list-style-type: none"> <li>• 2019 онд 499 сая тон хүлэмжийн хийг ялгаруулсан</li> <li>• Хүлэмжийн хийн ялгаруулалтаар 14-т</li> <li>• Нэг хүнд ногдох нүүрсний эрчим хүчний CO<sub>2</sub> ялгаруулалтаар 1-т</li> <li>• 2021 онд хүлэмжийн хийн ялгаруулалт нь 2005 оны түвшнээс 20.8%- аар буурсан</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хүлэмжийн хийн ялгаруулалтын бууралт нь тээврийн салбарын ялгаруулалт буурсан, газар ашиглалт, сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулалттай холбоотой</li> <li>• 2030 он гэхэд ялгаруулалтыг 2005 оны түвшнээс 26-28%-аар бууруулах</li> <li>• CO<sub>2</sub> -ийн ялгаруулалт багатай эрчим хүчний технологи, эрчим хүчний бусад эх үүсвэр, эрчим хүчний хуримтлалд хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байна.</li> <li>• 2050 он гэхэд нүүрс төрөгчийн “0” түвшинд хүрнэ</li> </ul>

# Улс орнуудын бодлогууд



Улсууд	Одоогийн нөхцөл байдал	Зорилго ба стратегиуд
Өмнөд Солонгос	<ul style="list-style-type: none"><li>Эрчим хүчний хэрэглээ нь нүүрс, байгалийн хийгээс ихээхэн хамаардаг (нийт эрчим хүчний хэрэглээний 82.5%)</li><li>Нүүрсний цахилгаан станц барих санхүүжилтийг зогсоосон, зарим станцуудыг хааж байгаа</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгаруулалтаа 2018 оны түвшнээс 30% бууруулна</li><li>Эрчим хүчний үр ашгийг сайжруулах, сэргээгдэх болон ус төрөгчийн эрчим хүчийг хөгжүүлэх, нүүрс төрөгчийн шингээлтийг сайжруулах, үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг сайжруулах</li><li>2040 он гэхэд сэргээгдэх эрчим хүчийг нийт эрчим хүчний нийлүүлэлтийн 35%-д хүргэх, 2050 он гэхэд эрчим хүчний гол эх үүсвэр болгох</li><li>2050 он гэхэд нүүрс төрөгчийн “0” түвшинд хүрнэ</li></ul>

## Улс орнуудын бодлогууд



- Хүлэмжийн хийн ялгаруулалтыг мэдэгдэхүйц бууруулах бүх улс оронд тохирдог арга гэж байдаггүй
- Улс орнууд өөрсдийн онцлогтоо тулгуурлан өөрсдийн стратеги баримталж байна:
  - ОХУ - эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх
  - Индонез – ойн хомсдолтой тэмцэх, газрын менежментийг сайжруулах
  - БНХАУ – салхи, нарны эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх
- Өмнөд Солонгос, Австрали зэрэг орнууд сэргээгдэх эрчим хүч болон технологийн хөгжилд илүүтэй хөрөнгө оруулж байгаа
- Бүх орнууд сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэхэд анхаарч байна



*Монголын өнөөгийн байдал болон  
баримталж буй бодлогууд*

# Монголын нүүрсний салбар

- Монголын нүүрсний салбар сүүлийн 10 жилд хурдацтай өссөн
- 2019 онд
  - Үйлдвэрлэл дээд хэмжээндээ хүрсэн – 55.8 сая тонн
  - Экспортын хэмжээ 32.5 сая тонн (3 тэрбум USD, нийт экспортын 40%)
  - Улсын төсвийн орлогын 10%-ийг бүрдүүлсэн
- Ковид-19-өөс болж нүүрсний салбар уналтад орсон
- Засгийн газар Ковид-19-ийн дараа эдийн засгийг сэргээхийн тулд нүүрсний экспорт, үйлдвэрлэлийг дэмжихээр төлөвлөж байна
- Дотоодын эрчим хүчний үйлдвэрлэлд нүүрсний эрчим хүч зонхилдог
- 2019 оноос Улаанбаатар хотод түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон

Монголын нүүрсний үйлдвэрлэл, экспорт, сая тонн



Дотоодын нүүрсний хэрэглээ, сая тонн




# Монголын нүүрстөрөгчийн хийн ялгаруулалт



- 2019 онд Монголын CO<sub>2</sub>-ийн ялгаруулалт түүхэн дээд хэмжээнд хүрэв- 88.7 сая тонн (Дэлхийн банк)
- CO<sub>2</sub> болон ДНБ-ий өсөлт ижил хандлагатай байна
- 2010 оноос өмнө CO<sub>2</sub>-ийн ялгаруулалт ДНБ-ээс бага хурдтай өсөж байсан
- 2010 оноос хойш нүүрсний олборлолт, экспорт мэдэгдэхүйц нэмэгдсээр өсөлт хурдассан

Монголын CO<sub>2</sub>-ийн ялгаруулалт ба ДНБ-ий өсөлт



Эх сурвалж: World Bank;  
Global Carbon Project;  
OurWorldInData.org

# Монголын бодлого



## Парисын хэлэлцээр

- Үндэсний зорилтоо баталсан:
  - Засгийн газрын тогтоол №407- хүлэмжийн хийн ялгаруулалтыг суурь түвшнээс 22.7%- аар бууруулах
  - КОП 26 уулзалт – зорилтыг 27.2%-д хүргэж, 2030 он гэхэд тэрбум мод тарьж, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулахад ДНБ-ий 1%-ийг зарцуулах
- Зорилгод хүрэхийн тулд дараах ажлуудыг хийнэ:
  - Эрчим хүчний салбар- Эрчим хүчний хангамжийн үр ашиг, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлнэ
  - Хөдөө аж ахуй - Малын өсөлтийг хязгаарлаж, чанар, ашиг шимийг дээшлүүлнэ
  - Аж үйлдвэрлэл - Үйлдвэрлэлийн эрчим хүчийг хэмнэх, нүүрсний уурхайгаас метан хийг олборлож цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, цементийн үйлдвэрлэлд нунтаг үнс ашиглах
  - Тээврийн салбарт- Евро-5 стандартын түлш, нүүрс экспортод авто замаас төмөр зам руу шилжих
  - Барилгын салбарт- Улаанбаатар хотод сайжруулсан нүүрсийг ашиглах, хуучирсан орон сууцыг дулаалах
  - Хог хаягдлын салбарт-Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих

## Алсын хараа 2050– урт хугацааны хөгжлийн бодлого

- Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулна
  - Сэргээгдэх эрчим хүчийг дэмжиж, эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, зам тээвэр, хүнд болон хөнгөн үйлдвэр, хог хаягдал зэрэг салбар дахь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх
- 2050 онд нүүрс төрөгчийн төвийг сахисан түвшинд хүрэх
  - Хүлэмжийн хийн ялгаралтыг 2025 онд суурь үеэс 12.3 %-аар, 2030 онд 22%-аар бууруулна.

## **Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2020-2024**

- Дотоодын хэрэглээнд зориулж сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ
- Санхүүжилт болон технологи тодорхой бус
- ЗГ нүүрсний олборлолт болон экспортыг дэмжих, өргөжүүлэхээр төлөвлөж байна
  - Таван толгойд нүүрс угаах үйлдвэр барина
  - Үйлдвэр, технологийн парк байгуулна
  - Ойрын жилүүдэд хэд хэдэн нүүрсний цахилгаан станц байгуулахаар төлөвлөсөн

**Нүүрсний салбар эдийн засгийн ач холбогдол ихтэй тул нүүрсний олборлолт, хэрэглээг шууд хязгаарлах бодолгүй байна.**

**Бэрхшээл: "Дэлхийн нүүрстөрөгчийг бууруулах шаардлага" ба "Монголын эрчим хүчний салбарын орлогын тогтвортой байдал"-ын аль нэгийг сонгох**

*Арга зүй болон шинжилгээний  
хувилбарууд*

# Динамик CGE загвар



- 2021-2030 оны урт хугацааны эдийн засгийн суурь төсөөллийг боловсруулсан
- CO<sub>2</sub> ялгаруулалтын түвшин болон CO<sub>2</sub> ялгаруулалтын функцээр өргөтгөсөн
- Үндсэн тоон мэдээлэл-Монголын Нийгмийн Тооцооллын Матриц-2018
- GТАР 7 мэдээллийн сангаас CO<sub>2</sub> ялгаруулалтын хэмжээг тооцоолсон



## Шинжилгээний хувилбарууд

**Суурь хувилбар:** Нүүрстөрөгчийг бууруулах бодлого хэрэгжихгүй

**Хувилбар 1:** 2030 он гэхэд сэргээгдэх эрчим хүчний салбарын хүчин чадлыг эрчим хүчний салбарын нийт хүчин чадлын 30%-д хүргэнэ

**Хувилбар 2:** 2030 он гэхэд Улаанбаатар хотын нүүрс хэрэглэдэг бүх өрх болон хөдөөгийн нүүрс хэрэглэдэг өрхийн 40%-г сайжруулсан түлшээр хангана

**Хувилбар 3:** 2025 оноос хойш түүхий коксжих нүүрсний салбарт шинээр хөрөнгө оруулалт хийхгүй, 2025 оноос хойш угаасан коксжих нүүрсний салбарт оруулах хөрөнгө оруулалт 75 %-аар буурна

**Хувилбар 4:** Хувилбар 1, 2, 3-ын бодлогуудыг нэгэн зэрэг хэрэгжүүлэх

## Хувилбар 1: Сэргээгдэх эрчим хүчний салбарын хүчин чадлыг өсгөх



Суурилагдсан хүчин чадал, сая ватт			
	2020	2030*	Өсөлт %
Уламжлалт эрчим хүч	1211.8	1822.8	50%
Сэргээгдэх эрчим хүч	271.2	782.2	188%
Дизель эрчим хүч	2.3	2.3	0%
<b>Нийт</b>	<b>1485.3</b>	<b>2607.3</b>	<b>76%</b>
<b>Сэргээгдэх эрчим хүчний нийт суурилагдсан эрчим хүчний үйлдвэрлэлд эзлэх хувь</b>			
	18.3%	30.0%	

\*судлаачдын тооцоолол, эх сурвалж: “Алсын хараа 2050” баримт бичиг

- 2020 онд сэргээгдэх эрчим хүчний салбар дотоодын нийт цахилгаан эрчим хүчний 7.1%-ийг үйлдвэрлэж, суурилагдсан хүчин чадлын 18.3%-ийг эзэлж байсан
- 2021-2030 онд сэргээгдэх эрчим хүчний салбарт 1.5 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийнэ
- Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл 1.8 дахин өснө
- Уламжлалт эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалт буурна

## Хувилбар 2: Сайжруулсан түлшний үйлдвэрлэл болон хэрэглээ өсөх



- Сайжруулсан түлшний хэрэглээ 2020 онд :
  - Монголын нийт өрхийн 28 хувь
  - Улаанбаатар хотын нийт өрхийн 77 хувь
- Таамаглал-2030 онд
  - Монголын нийт өрхийн 60 хувь нь сайжруулсан түлш хэрэглэнэ
    - ❖ Улаанбаатар хотын бүх өрх сайжруулсан түлш ашиглана
    - ❖ Орон нутгийн өрхийн 40 хувь нь сайжруулсан түлш ашиглана
  - Сайжруулсан түлшний салбарт хөрөнгө оруулалт нэмэгдэнэ

## Хувилбар 3: Экспортын болон коксжих нүүрсний салбарт хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл буурах




- Таамаглалууд
  - 2025 оноос хойш экспортын нүүрсний салбарт (түүхий коксжих нүүрс) хөрөнгө оруулалт хийгдэхгүй
  - 2030 он гэхэд түүхий коксжих нүүрсний экспорт 2025 онтой харьцуулахад 25%-аар буурна
  - 2030 он гэхэд угаасан коксжих нүүрсний хөрөнгө оруулалт 2025 онтой харьцуулахад 75% -аар буурна
  - 2030 он гэхэд угаасан коксжих нүүрсний үйлдвэрлэл 2025 онтой харьцуулахад 10%-аар буурна
  - Бид ГШХО-ыг түүхий болон угаасан коксжих нүүрсний салбарын хөрөнгө оруулалтын бууралттай тэнцэхүйц хэмжээгээр буурна гэж үзсэн

# CO<sub>2</sub> –ийн ялгаруулалт

- GTAP 7 мэдээллийн сангаас CO<sub>2</sub> –ийн ялгаруулалтын хэмжээг авч ашигласан
- Салбарын завсрын хэрэглээ болон өрхүүдийн хэрэглээнээс үүссэн CO<sub>2</sub> –ийн ялгаруулалтыг тооцоолж ашигласан.

CO<sub>2</sub> –ийн ялгаруулалт салбараар ,%



Өрхүүдийн хэрэглээнээс үүссэн CO<sub>2</sub> –ийн ялгаруулалт, %


	Эзлэх хувь
Нүүрс ашиглалт	68.5
Шатахуун ашиглалт	31.3
Цахилгааны ашиглалт	0.1
Сайжруулсан түлш ашиглалт	0.001
Нийт	

# *Шинжилгээний үр дүн*

# Хувилбар 1: Сэргээгдэх эрчим хүчний салбарын хүчин чадлыг өсгөх



Сэргээгдэх эрчим хүч (баруун гар) болон эрчим хүчний салбарын (зүүн гар) үйлдвэрлэл, тэрбум төгрөг



- Эрчим хүчний салбар нь цахилгаан болон дулаан үйлдвэрлэдэг бөгөөд цахилгаан дулааны түгээлтийг хийдэг
- 2020 онд сэргээгдэх эрчим хүч нийт эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийн 2.2%-ийг бүрдүүлсэн
- 2030 онд сэргээгдэх эрчим хүчний салбар нийт эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийн 4.5%-ийг л бүрдүүлэхээр байна

- Сэргээгдэх эрчим хүчний салбарын үйлдвэрлэл 2021-2030 онд 1.8 дахин нэмэгдэнэ
- Сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан хүчин чадал нийт эрчим хүчний салбарын суурилагдсан хүчин чадлын 30 хувь хүртэл нэмэгдэнэ

# Хувилбар 1: Сэргээгдэх эрчим хүчний салбарын хүчин чадлыг өсгөх




	Дундаж өсөлт %: 2021-2030				
	Суурь хувилбар	Хувилбар 1	Хувилбар 2	Хувилбар 3	Хувилбар 4
<b>ДНБ-ий өсөлт</b>	4.76	4.71	4.76	4.73	4.69
<b>Засгийн газрын орлого</b>	4.46	4.46	4.46	3.45	3.44
<b>Өрхийн орлого/хэрэглээ</b>	4.40	4.40	4.40	3.42	3.41
<b>Цалингийн түвшин</b>	2.33	2.32	2.34	1.18	1.17
<b>Нийт хөрөнгө оруулалт</b>	4.70	4.69	4.70	2.34	2.33
<b>Экспорт</b>	4.33	4.32	4.33	3.62	3.61
<b>Импорт</b>	4.43	4.42	4.43	3.16	3.15
<b>Өрхийн CO<sub>2</sub> ялгаруулалт</b>	5.15	4.86	0.00	4.17	-1.02
<b>Салбаруудын CO<sub>2</sub> ялгаруулалт</b>	4.42	4.28	4.44	4.24	4.13
<b>Нийт CO<sub>2</sub> ялгаруулалт</b>	4.49	4.36	4.06	4.23	3.71

- Эдийн засагт томоохон нөлөө үзүүлэхгүй
- Өрхийн CO<sub>2</sub> ялгаруулалтын дундаж өсөлт 0.29 пунктээр буурч байна
- Салбаруудын CO<sub>2</sub> ялгаруулалтын дундаж өсөлт 0.14 пунктээр буурч байна




## Хувилбар 2: Сайжруулсан түлшний үйлдвэрлэл болон хэрэглээ өсөх

Сайжруулсан түлшний үйлдвэрлэл, тэрбум төгрөг




Өрхүүдийн CO<sub>2</sub> ялгаруулалт, сая тонн




- 2030 он гэхэд Монголын нийт өрхийн 60% нь сайжруулсан түлш ашиглана
- Эдийн засагт томоохон нөлөө үзүүлэхгүй
- Өрхийн CO<sub>2</sub> ялгаруулалтын дундаж өсөлт тэг байна
- 2030 онд Өрхийн CO<sub>2</sub> ялгаруулалт хэмжээ нь суурь хувилбараас 39.8%-аар бага байна

## Хувилбар 3: Экспортын болон коксжих нүүрсний салбарт хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл буурах

Экспортын нүүрс болон коксын салбарын хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг




Экспортын нүүрс, кокс болон химийн салбарын үйлдвэрлэл, тэрбум төгрөг



- ДНБ-ий дундаж өсөлт 0.03 пунктээр буурахаар байна
- ГШХО буурсантай холбоотойгоор нийт хөрөнгө оруулалтын дундаж өсөлт 2.36 пунктээр буурч байна
- Ажиллах хүч харьцангуй бага цалинтай салбарт шилжиж, дундаж цалингийн өсөлт 1.15 пунктээр буурч байна
- Өрхийн орлогын дундаж өсөлт 0.98 пунктээр саарч байна
- Нийт импортын дундаж өсөлт 1.27, экспорт 0.71 пунктээр тус тус буурч байна
- Өрхийн CO<sub>2</sub> ялгаруулалтын дундаж өсөлт 0.97 пунктээр буурч байна.
- CO<sub>2</sub> ялгаруулалтын дундаж өсөлт 0.26 пунктээр буурч байна

## Хувилбар 3: Экспортын болон коксжих нүүрсний салбарт хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл буурах

Салбаруудын үйлдвэрлэлийн дундаж өсөлт, %, 2021-2030



Дотоодын нүүрс, экспортын нүүрс, кокс болон химийн үйлдвэрлэл, барилга, худалдаа, тээвэр, төрийн удирдлага, удирдлагын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбаруудын үйлдвэрлэлийн дундаж өсөлт суурь хувилбартай харьцуулахад бага зэрэг буурахаар байна.


Газрын тос, металлын хүдэр, бусад уул уурхай, аж үйлдвэр, сэргээгдэх эрчим хүч, усан хангамж, зочид буудал, нийтийн хоол болон төрийн захиргааны салбарын үйлдвэрлэлийн дундаж өсөлт нэмэгдэхээр байна.

Салбаруудын нүүрстөрөгчийн ялгаруулалтын дундаж өсөлт 0.18 пунктээр буурахаар байна.

## Хувилбар 4


- Макро эдийн засагт үзүүлэх нөлөө нь Хувилбар 3-тай төстэй байна.
- Сайжруулсан түлш болон сэргээгдэх эрчим хүчний салбаруудын үйлдвэрлэлийн дундаж өсөлтийн хурд нэмэгдэхээр байна.
- Дотоодын болон экспортын нүүрс, кокс ба химийн үйлдвэрлэл, эрчим хүч, барилга, худалдаа, тээвэр, санхүүгийн үйл ажиллагаа, үл хөдлөх хөрөнгө, төрийн удирдлага, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарын үйлдвэрлэлийн дундаж өсөлт саарч байна.
- Бусад салбарын үйлдвэрлэлийн өсөлт бага зэрэг хурдасч байна.

Салбаруудын үйлдвэрлэлийн дундаж өсөлт, %, 2021-2030




## Хувилбар 4

Өрхүүдийн CO<sub>2</sub>-ийн ялгаруулалт, сая тонн 2020-2030



Нийт CO<sub>2</sub> –ийн ялгаруулалт, сая тонн 2020-2030



- 2030 онд өрхийн CO<sub>2</sub> –ийн ялгаруулалт суурь хувилбартай харьцуулахад 45.9%-аар бага байна.
- 2030 онд НИЙТ CO<sub>2</sub> –ийн ялгаруулалт суурь хувилбартай харьцуулахад 2.8%-аар буурахаар байна.

# *Дүгнэлт*

## Дүгнэлт



- Монгол Улс бодлого боловсруулахдаа бусад орнуудын нүүрстөрөгчийн хийг бууруулах бодлогыг харгалзан үзэх ёстой. Засгийн газрын бодлогод уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг бууруулах, ялангуяа БНХАУ зэрэг орны нүүрстөрөгчийн хийг бууруулах, нүүрсний хэрэглээг хязгаарлах бодлого манай улсын уул уурхайн салбарт хэрхэн нөлөөлөх талаар тусаагүй.
- Монголын эдийн засаг уул уурхайн салбараас ихээхэн хамааралтай тул нүүрсний салбарын хөрөнгө оруулалт, олборлолт буурвал уул уурхайгаас хамааралтай салбаруудын үйл ажиллагаа удааширч, макро-эдийн засгийн үзүүлэлтүүдэд сөргөөр нөлөөлөхөөр байна.
- Дэлхий дахинд нүүрсний хэрэглээг хумих бодлого баримталж байгаа тул манай улс уул уурхайн бус салбараа төрөлжүүлэх, хөгжүүлэх шаардлага улам нэмэгдэж байна.
- Өрхүүдийн CO<sub>2</sub>-ийн ялгаруулалтын 68.5 хувь нь түүхий нүүрс түлснээс үүдэлтэй. Тиймээс сайжруулсан түлшний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, өрхүүдэд нийлүүлэх бодлого өрхийн CO<sub>2</sub>-ийн ялгаруулалтыг бууруулахад нөлөө үзүүлнэ.

## Дүгнэлт



- Засгийн газраас эрчим хүчний салбар дахь зөрчилтэй зорилтуудаа нэгтгэх шаардлагатай байна. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилт тавьж байгаа ч ойрын хугацаанд нүүрсээр ажилладаг хэд хэдэн цахилгаан станц барихаар төлөвлөж байна. Хэрэв эрчим хүчний салбар нүүрснээс хамааралтай хэвээр байвал сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар CO<sub>2</sub> ялгаруулалтыг бууруулах бодлого үр нөлөөгүй болно.
- Сэргээгдэх эрчим хүчний салбарын үйлдвэрлэл 2020 онд эрчим хүчний салбарын нийт үйлдвэрлэлийн дөнгөж 2.2%-ийг эзэлж байна. Иймээс сэргээгдэх эрчим хүчний салбарын суурилагдсан хүчин чадал сайжирсан ч эрчим хүчний салбарын нийт үйлдвэрлэлд эзлэх хувь бага хэвээр байх төлөвтэй байна. Энэ нь сэргээгдэх эрчим хүчний салбарын суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын үр нөлөөг сулруулахаар байна.
- CO<sub>2</sub> ялгаруулалтыг бууруулахад мэдэгдэхүйц ахиц гаргахын тулд сэргээгдэх эрчим хүчний салбарын суурилагдсан хүчин чадлыг өргөтгөх, уламжлалт эрчим хүчний салбарт оруулах хөрөнгө оруулалтыг хязгаарлах, нийт эрчим хүчний салбарын үр ашгийг дээшлүүлэх шаардлага тавигдаж байна.



*Анхаарал тавьсанд баярлалаа*